




**“ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН
ШАГНАЛ, УРАМШУУЛЛЫН ЖУРАМ”
/Шинэчлэн найруулсан/**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Үндэсний батлан хамгаалахын их сургууль /цаашид “Их сургууль” гэх/ -ийн ажлын бүтээмжийг дээшлүүлэхийн тулд нийт бие бүрэлдэхүүний үр бүтээлтэй ажиллах, суралцагчдын үр бүтээлтэй сурах, өөрийгөө хөгжүүлэх идэвх санаачилга, урам зоригийг хөхүүлэн дэмжихэд оршино.

1.2. Албан хаагч, ажилтан нь албан тушаалын тодорхойлолтоор болон гүйцэтгэлийн (хөдөлмөрийн гэрээ) төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ үлгэр жишээ биелүүлж, онцгой амжилт гаргасан, сонсогч, сурагчид сурлага, эрдэм шинжилгээ, бие бялдрын бэлтгэлжилт, гадаад хэлний мэдлэгээр онцгойлох амжилт гаргасан, урлаг, спортоор олон улс, улс, бүсийн болон салбарын чанартай тэмцээн, уралдаанд амжилт үзүүлсэн, сахилга, ёс зүйтэй байхыг бусдад үлгэрлэсэн байдал нь шагнаж урамшуулах үндсэн шалгуур болно.

1.3 АИХ-ын Тэргүүлэгчдийн 1990 оны 148, 149 дүгээр зарлиг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол, одон медалиар шагнах журам”, “Төрийн албаны тухай”, “Төсвийн тухай” хууль, Батлан хамгаалахын сайдын 2023 оны А/395 дүгээр тушаалаар батлагдсан “Батлан хамгаалах салбарын шагнал олгох журам” болон Монгол Улсын Засгийн газар, яам, агентлагууд, төрийн бусад байгууллагуудаас батлан гаргасан шагналын журмуудыг үндэслэл болгон Төрийн дээд болон холбогдох байгууллагуудад өргөн мэдүүлж, шагнах арга хэмжээг зохицуулна.

Хоёр. Их сургууль нь дараах цол, шагнал, урамшууллын төрөлтэй байна. Үүнд:

2.1. Цолны төрөл

2.1.1 Их сургуулийн “Хүндэт Доктор”

2.1.2 Их сургуулийн “Хүндэт Профессор”

2.2 Шагналын төрөл

2.2.1 Их сургуулийн “Хүндэт тэмдэг”

2.2.2. Их сургуулийн “Шилдэг төгсөгч” алтан медаль

2.2.3 Их сургуулийн “Эрдмийн Алдар” тэмдэг

2.2.3 Их сургуулийн “Шилдэг суралцагч” тэмдэг

2.3. Урамшууллын төрөл

Их сургуулийн багш, судлаач, суралцагчдыг жил бүр дараах төрлөөр шалгаруулан урамшуулна. Үүнд:

2.3.1. Суралцагчид:

- а. Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цалин
- б. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит шилдгийн шилдэг сонсогч
- в. Бие бялдрын бэлтгэлжилтийн онцгойлох үнэлгээний урамшуулал цалин
- г. Гадаад хэл эзэмшсэний урамшуулал цалин
- д. Судалгааны ажлын онцгойлох амжилт үзүүлсний урамшуулал цалин
- е. Бусад

2.3.2. Багшлах бүрэлдэхүүн, хамт олон:

- а. Тэргүүний сургууль
- б. Тэргүүний тэнхим (дээд боловсролын, мэргэжлийн болон техникийн боловсролын)
- в. Тэргүүний багш (дээд боловсролын, мэргэжлийн болон техникийн боловсролын, ерөнхий боловсролын)
- г. Тэргүүний сургалтын менежер
- д. Тэргүүний залуу багш
- е. Тэргүүний арга зүйч багш
- ё. Тэргүүний судлаач багш

2.3.3 Судалгаа, бүтээл:

- а. Багш, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны шилдэг бүтээл:
 - "Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн түүх"
 - "Цэргийн зэвсэглэл, техник технологи"
 - "Нийгэм, байгаль, хүмүүнлэгийн ухаан" чиглэлээр тус бүр 1 бүтээл.
- б. Суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгааны шилдэг бүтээл:
 - "Цэргийн ухаан"
 - "Инженер, технологи"
 - "Нийгэм, байгаль, хүмүүнлэгийн ухаан" чиглэлээр тус бүр 1 бүтээл.

2.4 Их сургуулийн нийт бие бүрэлдэхүүний дотроос дараах болзол шалгуур хангасан ажилтан, албан хаагчдад мөнгөн шагнал олгох, цалингийн хувиар урамшуулах, ахисан түвшний оюутан, сонсогчдыг төлбөрөөс нь 50 хүртэл хувиар хөнгөлж болно. Үүнд:

2.4.1 Олон улсын болон Улсын чанартай олимпиад, эрдэм шинжилгээний бүтээл, илтгэл шалгаруулах уралдаанд шагналт болон тусгай байр эзэлсэн;

2.4.2 Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний шинэчлэлд хувь нэмэр оруулахуйц, шинэ санаа, оюуны бүтээл, инновац, эрдэм шинжилгээний бүтээл нь эрдмийн зөвлөлөөр дэмжигдэн хэрэглээ, үйлдвэрлэлд нэвтэрсэн;

2.4.3 Олон улсын болон улс, салбарын чанартай спорт, урлагийн тэмцээн уралдаанд ҮБХИС-ийн нэрийн өмнөөс оролцон шагналт байр эзэлсэн бол их сургуулийн захирлын шийдвэрээр;

2.5 Их сургуулийн хэмжээнд жилийн эцсийн ажлын үр дүн, амжилтыг үндэслэн "Оны тэргүүний офицер", "Оны тэргүүний ахлагч", "Оны тэргүүний удирдах ажилтан, захиргааны ажилтан, үйлчилгээний ажилтан", "Оны тэргүүний бүтцийн нэгж"-ийг шалгаруулж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнана.

Гурав. Цол, Шагнал, урамшууллын шалгуур, олгох хугацаа:

3.1 Их сургуулийн "Хүндэт доктор" цолыг тус сургуулийг хөгжүүлэх болон батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаанд жинтэй хувь нэмэр оруулсан дотоод, гадаадын эрдэмтэд, төр цэргийн нэрт зүтгэлтнүүдэд дараах болзлыг харгалзан хүртээнэ. Үүнд:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалах үйлсэд баатарлаг гавьяа байгуулсан төр, нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн;

- Боловсролын байгууллагад 20-оос доошгүй, түүний дотор ҮБХИС-д 10-аас дээш жил ажилласан эрдмийн зэрэг бүхий эрдэмтэн, судлаач, профессор цолтой багш нар;

- Тус их сургуулийг 10-аас доошгүй жил удирдаж тодорхой амжилтад хүргэсэн эрдмийн зэрэг бүхий захирал, дэд захирлууд;

- Тус их сургуулийг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулан дэмжлэг үзүүлсэн Монгол болон гадаадын эрдэмтэд, төр, цэргийн зүтгэлтнүүд;

3.2 Их сургуулийн "Хүндэт профессор" цолыг тус сургуулийг хөгжүүлэх болон сургалтын үйл ажиллагаа, технологийг дээшлүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан дотоод, гадаадын их дээд сургуулийн багш, удирдах ажилтан нарт дараах болзлыг харгалзан хүртээнэ. Үүнд:

- Тус сургуульд 20-аас дээш жил өндөр үр бүтээлтэй ажилласан багш, эрдэм шинжилгээний ажилтан;

- Тус сургуулийг 10-аас доошгүй жил удирдаж тодорхой амжилтад хүргэсэн захирал, дэд захирлууд;

- Тус сургуулийг хөгжүүлэхэд үлэмж хувь нэмэр оруулсан гадаад орны эрдэмтэд, багш, сургуулийн удирдах ажилтнууд;

3.3 Их сургуулийн "Хүндэт тэмдэг"-ийг байгууллагыг хөгжүүлэх, сурталчлан таниулах үйлсэд жинтэй хувь нэмэр оруулсан, 10-аас дээш жил ажиллаж байгаа удирдах ажилтан, 20-оос доошгүй жил ажиллаж байгаа албан хаагч, ажилтанд жилд 1-3 хүнд;

3.4 "Шилдэг төгсөгч" алтан медалийг их сургуулийн бакалаврын хөтөлбөрийн болон цэргийн дээд мэргэжлийн үндсэн ангийг онцгойлох үнэлгээтэй төгссөн, хамт олондоо нэр хүнд бүхий тус бүр нэг сонсогчид;

3.5 Их сургуулийн "Эрдмийн алдар" тэмдгийг эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйг эзэмшин мэргэжлийн чиглэлээр судалгааны ажил хийж инновац бүтээсэн, Зэвсэгт хүчинд нэвтрүүлсэн, олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд өгүүлэл нийтлүүлсэн жилд 1 сонсогчид;

3.6 Их сургуулийн "Шилдэг суралцагч" медалийг тухайн жилийн сургалтын хамгийн өндөр голч үнэлгээг үзүүлсэн бакалаврын хөтөлбөрийн 3-4 дүгээр ангийн жилд 1 сонсогчид;

3.7 "Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цалин"-г 4 буюу түүнээс дээш улирал 3.8-аас дээш үнэлгээтэй суралцсан, гадаад хэл, бие бялдрын бэлтгэлжилтийн стандарт түвшинг хангасан сонсогчийг шалгаруулан 2 улирал үндсэн цалингийн 25 хувийн нэмэгдэл, ялгах тэмдэг;

3.8 Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит шилдгийн шилдэг сонсогчийн шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн

Тамгын газраас батлан гарсан журмын шаардлагын дагуу шалгаруулан өргөн мэдүүлнэ.

3.9 “Бие бялдрын бэлтгэлжилтийн онцгойлох үнэлгээний урамшуулал цалин”-г сонсогчийн бие бялдрын бэлтгэлжилтийн стандартын долоо, зургаа, тавдугаар түвшний болзлыг хангасан сонсогчийг улирал тутам шалгаруулан үндсэн цалингийн 15, 10, 5 хувийн нэмэгдэл, ялгах тэмдэг;

3.10 “Гадаад хэл эзэмшсэний урамшуулал цалин”-г гадаад хэлний стандарт шалгалт (IBT, IELTS, HSK, TOPIC, JLPT, TORFL)-г амжилттай өгч тэнцсэн сонсогчдод шалгалтын хүчинтэй хугацаанд, гадаад хэлний хичээлийн улирлын шалгалтад 2 удаа дараалан 95-аас дээш үнэлгээтэй шалгагдсан сонсогчдод нэг улирал үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдэл, ялгах тэмдэг;

3.11 “Судалгааны ажлын онцгойлох амжилт үзүүлсний урамшуулал цалин”-г шинэ санаа, оюуны бүтээл, инновац, эрдэм шинжилгээний бүтээл туурвиж үндэсний хэмжээнд амжилт гаргасан сонсогч, багийг шалгаруулан 2 улирал үндсэн цалингийн 20 хувийн нэмэгдэл тус тус олгоно.

3.12 “Тэргүүний сургууль, тэнхим, багш, сургалтын менежер, залуу багш, арга зүйч багш, судлаач багш”-ийг жил бүрийн багш нарын өдрийг угтан их сургуулийн захирлын баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын хэсэг шалгаруулна.

3.13 Их сургуулийн багш, судлаач, суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгааны шилдэг бүтээлийг жил бүрийн хоёрдугаар улиралд “Эрдмийн их чуулган”-аар хэлэлцүүлэн шалгаруулна.

3.14 Сонсогчид олгох нэрэмжит тэтгэлэг, шагналд нэр дэвшигч нь нийгмийн идэвх санаачилгатай, ёс суртахууны зөв төлөвшил, хүмүүжилтэй, хамт олны дунд нэр хүндтэй хүлээн зөвшөөрөгдсөн байх нийтлэг шалгуур шаардлага хангасан байна. Бие бялдрын бэлтгэлжилтийн стандарт, ялгах тэмдгийн загварыг Захирлын тушаалаар батлан мөрдүүлнэ.

3.15 Сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг их сургуулийн багш, ажилтан, алба хаагч болон төрийн алба хаагчдад дараах шалгуурын дагуу үзүүлнэ. Үүнд:

- Их сургуульд 5 хүртэл жил ажилласан багш, ажилтан алба хаагчдад 50 хувь;

- Төрийн алба хаагчдад байгууллагын албан хүсэлт, судалж буй сэдвийн ач холбогдолд үндэслэн их сургуулийн захирлын шийдвэрээр 50 хүртэл хувь.

3.16 Эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд судалгаа, туршилт зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон Үндэсний аюулгүй байдлыг хангах, Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх бэлэн байдалд дорвитой хувь нэмэр оруулсан онол, арга зүйн сурах бичиг, нэг сэдэвт бүтээл /монограф/ болон зэвсэглэл техник технологийн бүтээгдэхүүнийг шалгаруулна.

Суралцагчийн эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд судалгаа, туршилт зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон, практик ач холбогдолтой, эдийн засгийн үр ашигтай, техник технологийн шинэ дэвшил, оновчтой шийдлийг гаргасан эрдэм шинжилгээний тайлан, өгүүлэл, илтгэл болон техник технологийн бүтээгдэхүүний ерөнхий шалгуур тавигдах ба тус бүр дараах шаардлага хангасан байна.

- шинжлэх ухаан, онол арга зүйн өндөр түвшинд туурвигдсан болон зохион бүтээгдсэн

- шинэ санаа, шинэ технологийг түгээн дэлгэрүүлэх инновацийн чиг хандлагатай байх

- тухайн жилдээ багтаж гарсан байх,
- мэргэжлийн тэнхим болон бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн дэмжсэн байх
- судалгааны ажлын үр дүнгээс дотоод гадаадын мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх
- сайжруулсан бүтээлийг зөвхөн нэг удаа дэвшүүлж болно.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, өргөн мэдүүлэх, шийдвэрлэх хугацаа

4.1. Монгол Улсын Төрийн дээд шагналд тодорхойлох асуудлыг "Монгол цэргийн өдөр", "Үндэсний их баяр наадам", "Монгол бахархлын өдөр", "Тусгаар тогтнолын өдөр" болон сургуулийн тэгш ойн баяраар, Батлан хамгаалах яамны шагналыг зөвхөн "Монгол цэргийн өдөр"-өөр, Боловсролын яамны шагналыг "Багш нарын өдөр"-өөр тус тус өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ.

4.2 Их сургуулийн шагналаар цэргийн албан хаагчдыг жил бүрийн "Монгол Цэргийн өдөр"-өөр, багш нарыг "Багшийн өдөр", "Шинжлэх ухааны ажилтны өдөр"-өөр, ажилтан, албан хаагчдыг Шинэ жилийн баяраар тус тус нэр дэвшүүлж, захирлын тушаалаар шагнал олгоно.

4.3 Төрийн дээд байгууллага болон бусад байгууллагуудаар шагнуулахаар өргөн мэдүүлэх саналыг бүрэлдэхүүн сургуулиудын захирлууд, бүтцийн нэгжийн дарга нар хариуцсан нэгжийнхээ /албан хаагч/ дэвшүүлсэн санал, тодорхойлолтыг судлан, ажлын амжилт, хамт олны санал, шагнал хоорондын хугацаа зэргийг харгалзан шийдвэрлэж, журмын 4.1, 4.2-т заасан шагналт баяр болохоос 45 хоногийн өмнө холбогдох материалыг бүрдүүлэн ҮБХИС-ийн Захиргаа удирдлагын хэлтэст ирүүлнэ. Хэрэв шагналын материалыг хугацаа хожимдуулж ирүүлсэн бол тодорхойлолтыг тухайн сургууль, нэгж рүү нь буцаана.

4.4 Ирүүлсэн материалуудыг Захиргаа удирдлагын хэлтэс хянан нэгтгэж, Батлан хамгаалах яам, Боловсролын яамны шагналыг ажлын 10 хоногийн дотор, Монгол Улсын төрийн дээд шагнал, Засгийн газрын болон бусад байгууллагуудын шагналаар шагнуулах асуудлыг ажлын 15 хоногийн дотор ҮБХИС-ийн захиргааны зөвлөлийн хуралдаанаар саналыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, холбогдох байгууллагуудад тус тус өргөн мэдүүлнэ.

4.5 Их сургуулийн "Хүндэт доктор", "Хүндэт профессор" цолыг 2-3 жилд нэг удаа сургууль байгуулагдсаны ойн өдрийг тохиолдуулан тус сургуулийн бүрэлдэхүүн сургуулиуд болон удирдах бүрэлдэхүүн, хамт олны саналыг үндэслэн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, Захирлын тушаалаар баталгаажуулан хүртээнэ.

4.6 Их сургуулийн "Хүндэт тэмдэг"-ийг бүрэлдэхүүн сургуулиуд болон удирдах бүрэлдэхүүн, хамт олны саналыг үндэслэн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, Захирлын тушаалаар баталгаажуулан, жил бүр ҮБХИС-ийн ойгоор олгоно.

4.7 Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит шилдгийн шилдэг сонсогчийн материалыг Сургалтын хэлтэс бүрэлдэхүүн сургуулиудаас авсан саналын үндсэн дээр шалгаруулан материалыг жил бүрийн 1 дүгээр сард өргөн мэдүүлнэ. Жанжин Сүхбаатарын нэрэмжит цалинд өргөмжлөх, "Шилдэг суралцагч" тэмдэг хүртээх сонсогчийг жил бүр ҮБХИС-ийн ойгоор, "Шилдэг төгсөгч" алтан меаль хүртээх сонсогчийг жил бүрийн төгсөлтийн ёслолоор,

Судалгааны ажлын онцгойлох амжилт үзүүлсний урамшуулал цалинд өргөмжлөх, “Эрдмийн алдар” алтан медаль хүртээх сонсогчийг жил бүрийн хоёрдугаар улиралд “Эрдмийн их чуулган”-аар, Бие бялдрын бэлтгэлжилтийн онцгойлох үнэлгээний урамшуулал цалин, Гадаад хэл эзэмшсэний урамшуулал цалин хүртээх сонсогчдыг тухай бүр Сургалтын хэлтэс, Эрдэм шинжилгээ, инновацын хэлтэс чиглэл бүрээр шалгаруулан Захирлын тушаалаар баталгаажуулна.

4.8 Тэргүүний сургууль, тэнхим, багш, сургалтын менежер, залуу багш, арга зүйч багш, судлаач багш нарыг жил бүрийн 09 дүгээр сарын 25-ны дотор их сургуулийн хэмжээнд 2 үе шаттайгаар зохион байгуулна. Нэгдүгээр шатны шалгаруулалтыг бүрэлдэхүүн сургуулиуд дотроо 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулж, шалгарсан тэнхим багшийн ажлын дүнг батламжлан холбогдох материалын хамт 09 дүгээр сарын 15-ны дотор Сургалтын хэлтэст уламжлан. Тус нэгжээс хариуцан сонгон шалгаруулах Төв комисс болон шалгуур үзүүлэлтийг захирлаар батлуулан шалгаруулж, дүнг тушаалаар баталгаажуулан “Алтан шонхор”, өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно.

4.9 Эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийг жил бүрийн 04 дүгээр сарын 05-ны дотор шалгаруулах ба шалгаруулалтаас 30 хоногийн өмнө Сургалтын хэлтэс, Эрдэм, шинжилгээ, инновацын хэлтсээс хариуцан шалгаруулах комисс болон шалгаруулалтад ирүүлэх материалын бүрдэл, шалгуур үзүүлэлтийг захирлаар батлуулж, сонгон шалгаруулалт явуулан дүнг тушаалаар баталгаажуулан өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно.

4.10 Их сургуулийн оны тэргүүний шалгаруулалт нь 2 үе шаттай явагдах ба бүрэлдэхүүн сургууль, бүтцийн нэгжүүд тухайн оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор багтаан дотооддоо зохион байгуулан явуулж, төрөл бүрт шалгарагчдыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн, хуралдааны тэмдэглэл, ажлын тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн хамт албан бичгээр 12 дугаар сарын 15-ны дотор Захиргаа удирдлагын хэлтэст ирүүлнэ. Ирүүлсэн материалуудыг үндэслэн 2 дугаар шалгаруулалтыг Захирлын тушаалаар батлагдсан комисс зохион байгуулан явуулах ба комисс баталсан тушаалтай хамт шалгуур үзүүлэлт, дагалдах мөнгөн шагналын хэмжээг тогтоон Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.

4.11 Тэтгэвэр, чөлөөндөө гарсан ахмадуудыг зөвхөн Монголын ахмадуудын өдөр болон билгийн улирлын хаврын тэргүүн сар-цагаан сарын шинийн нэгний баяраар “Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай” Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйлийн дагуу хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулна.

Тав. Шагналд өргөн мэдүүлэх материалын бүрдэл

5.1 Шагнуулахаар нэр дэвшүүлсэн албан хаагчдыг тодорхойлохдоо дор дурдсан материалыг бүрдүүлнэ. Үүнд:

а. Төрийн дээд цол, одон медалиар шагнуулах албан тушаалтны анкет /цээж зурагтай/

б. Бүрэлдэхүүн сургууль, бүтцийн нэгжийн даргаар баталгаажуулсан ажил, зан байдлын тодорхойлолт

в. Хамт олны хуралдааны тэмдэглэл

г. Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн шинэ технологийн болон гаргасан ном зохиолын жагсаалт

д. Холбогдох бусад материал

Зургаа. Шагнал олгох

6.1. Шагналыг их сургуулийн захирал, түүнээс эрх олгосон албан тушаалтан нийт бие бүрэлдэхүүний болон хамт олных нь өмнө хүндэтгэлтэй, баяр ёслолын байдалтайгаар гардуулна. Ёслолын арга хэмжээнд ар гэрийн төлөөллийг оролцуулж болно.

6.2. Шагнагдсан алба хаагч, ажилтан, суралцагчийн дурсгалын зураг авах, нийтэд мэдээлэн сурталчлах, сургуулийн түүхийн баримтад хадгалах ажлыг их сургуулийн холбогдох нэгж ажил үүргийн дагуу хариуцна.

Долоо. Шагнал, урамшуулалд дагалдах мөнгөн шагналын хувь, хэмжээ

7.1 Их сургуулийн "Хүндэт доктор", Хүндэт профессор" цолыг тус бүр 3,000,000 төгрөг, "Хүндэт тэмдэг"-ийг 1,000,000 төгрөг, "Эрдмийн Алдар" тэмдгийг 500,000 төгрөг, "Шилдэг суралцагч", "Шилдэг төгсөгч" алтан медалийг 300,000 төгрөг тус тус дагалдана.

7.2 Журмын 2.3.2-т заасан тэнхимд 10 багц цагийн мөнгөн дүнтэй тэнцэх, багш нарт 5 хүртэл багц цагийн мөнгөн дүнтэй тэнцэх урамшуулал тус тус олгоно.

7.4 Журмын 2.3.3 "а"-т заасан албан тушаалтан /баг/-д 10 багц цагийн мөнгөн дүнтэй тэнцэх, "б"-т заасан суралцагсдад 3 багц цагийн мөнгөн дүнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгоно.

Найм. Бусад зүйл

8.1 Их сургуулийг хөгжүүлэхэд оруулсан бодит хувь нэмрийг нь үнэлэн дэмжин хамтран ажиллаж буй гадаад дотоодын байгууллага, түүний зочин, төлөөлөгч болон хувь хүмүүсийг их сургуулийн шагналаар шагнаж болно.

8.2 Их сургуулийн "Хүндэт доктор", "Хүндэт профессор" цол хүртээн, өргөмжлөгдсөн хүнд малгай нөмрөг бүхий өмсгөл өмсгөнө. Өмсгөлийн загвар, тайлбарыг Их сургуулийн захирлын тушаалаар батлан мөрдүүлнэ.

8.3 Урамшуулал цалин хүртэж буй сонсогч тодорхой шалтгаанаар сургалтын чөлөө авсан болон сахилга, хариуцлагын зөрчил гаргасан тохиолдолд Сургалтын хэлтсийн саналыг үндэслэн цалинг захирлын тушаалаар зогсооно.

8.4 Байгууллагын шагналыг гэж үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд шагналын эзэн, түүнийг байхгүй бол гэр бүлийн гишүүдийн хүсэлт, хүндэтгэн үзэх шалтгааныг үндэслэн дахин нэг удаа тогтоосон үнээр олгож болно.

8.5 Шагналд зарцуулах мөнгөн хөрөнгийг их сургуулийн төсөв болон бусад эх үүсвэрээс зохих журмын дагуу гаргана.

8.6 Шагналын мэдээллийн санг Захиргаа удирдлагын хэлтсийн хүний нөөцөд баяжуулан хөтөлнө.

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ